



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

## БИЗНЕСИЙН ТӨЛӨВИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

2024 оны III улирал

2024 оны 11 сар



## I. Хураангуй


“Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажлыг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулж, эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрийн төлөөллийг хангасан нийт 378 аж ахуйн нэгжүүдээс мэдээлэл авч, судалгааны үр дүнг нэгтгэлээ. Судалгааны товч үр дүнгээс дурдвал:

- Судалгаанд ХХК өмчлөлийн хэлбэртэй, дотоод худалдаа, барилга, хүнсний болон хүнсний бус боловсруулах үйлдвэрлэлийн салбарын, 10-с дээш жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай, 200 хүртэл ажилчидтай, жилийн 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд түлхүү оролцлоо.
- Аж ахуйн нэгжүүдийн өгсөн хариултаас инфляцын хүлээлтийг тооцвол: 2024 оны IV улиралд чанарын хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга **4.8%**, мэдрэмжид суурилсан хүлээлтийн утга **4.9%**, тоон хариултаас тооцсон хүлээлтийн утга **6.9%**-тай байна. Харин ирэх 12 сард буюу 2025 оны III улиралд чанарын хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга **5.5%**, мэдрэмжид суурилсан хүлээлтийн утга **4.7%**, тоон хариултаас тооцсон хүлээлтийн утга **7.4%**-тай байна.
- Ирэх 3 сард холбоо, шуудан, тээврийн болон боловсролын үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд үйлчилгээний үнэ бага зэрэг нэмэгдэх хандлага түлхүү байгаа бол ирэх 12 сард мөн холбоо, шуудан, боловсрол, тээврийн үйлчилгээ болон хувцас бөс, барааны үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ одоогийнхоос бага зэрэг нэмэгдэх хүлээлт давамгайлж байна.
- Тайлант улирлын **эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт** өмнөх улирлаас 6 нэгж хувиар буурснаар **100** хувийн утгатай гарч, ирэх 3 сард эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй төлөвтэй гарлаа. Ийнхүү муудахад аж үйлдвэрийн салбарын өнгөрсөн улирлын эрэлтийн үзүүлэлт буурсан нь голлон нөлөөллөө.
- **Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт** тайлант улиралд **110** утгатай гарч өмнөх улирлаас 4 нэгж хувиар буурсан шилжилтийг хийсэн ч 100-с дээш утгатай хэвээр байна. Дотоод худалдаа болон үйлчилгээний салбаруудад ажил эрхлэлт нэмэгдэх хүлээлттэй байна.
- **Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт** тайлант улиралд өмнөх улирлаас 13 нэгж хувиар өсөж, **134** утгатай гарлаа. Бүх салбаруудын хувьд энэхүү үзүүлэлт өмнөх улирлаас нэлээдгүй өсөж, тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Харин хэрэглэгчдийн болгоомжлол бага зэргийн буурсан нь өрхийн хэрэглээ, худалдан авалтад эергээр нөлөөлөхөөр байна.
- Аж ахуйн нэгжүүдийн хувьд ирэх улиралд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт харьцангуй өндөр байх хүлээлттэй хэдий ч экспортын хүлээлт өмнөх улирлаас буурах төлөвтэй байна. Ажиллах хүчний зардал бага зэргийн нэмэгдэх хандлагатай бөгөөд хөрөнгө оруулалтын үзүүлэлт бага зэргийн буурах, мөн нэгж бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг нэлээдгүй нэмэгдэх хүлээлттэй байгаа нь цаашид үнэ өсөх суурь шалтгаан болохоор байна.
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас төдийлөн өөрчлөлтгүй төгрөг сулрах мужид сүүлийн 5 улирал дараалан хадгалагдаж байна. Харин 2023 оны эхнээс хойш тогтвортой байсан зээлийн хүүний үзүүлэлт энэ удаад бүх салбаруудад багагүй нэмэгдэж, зээлийн хүү өсөх хүлээлт нийт аж ахуйн нэгжүүдэд давамгайлж байна.

## II. Аж ахуйн нэгжүүдийн үнийн талаарх хүлээлт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс инфляц хэрхэн өөрчлөгдөх талаар асууж, чиглэлийн индексийг тооцоход ирэх 3 сарын болон ирэх 12 сарын чиглэлийн индексийн утга хоёул “үнийн өсөлт одоогийн түвшинд буюу инфляц хэвэндээ байна” гэсэн мужид хэвээр хадгалагдлаа. Гэсэн хэдий ч өмнөх улирлын утгаас нэлээдгүй өсөж, 2022 оны IV улирлын түүхэн дээд утгатай ойролцоо түвшинд ирлээ. Ингэснээр ирэх 12 сарын үнийн хүлээлтийн чиглэлийн индексийн утга 2020 оны III улирлаас хойш буюу сүүлийн 17 улирал дараалан “үнийн өсөлт одоогийн түвшинд хадгалагдах” мужид гараад байна /Зураг 1.1/.

Зураг 1.1: Инфляцын хүлээлтийн үзүүлэлт




Инфляцын хүлээлтийн талаарх ААН-үүдээс ирүүлсэн мэдээлэл дээр үндэслэн ирэх 3 сарын буюу 2024 оны IV улирлын инфляцын хүлээлтийн утгыг тооцоход<sup>1</sup> чанарын хариултын<sup>2</sup> хувьд **4.8%**, мэдрэмжид суурилсан хүлээлтийн утга **4.9%** байхаар хүлээгдэж байна. Энэ удаагийн судалгаагаар

<sup>1</sup> Хүлээлтийн утгыг тооцоходоо ХҮИ-д тулгуурлаж байгаа тул үнийн ерөнхий хандлагыг харуулна. Энэхүү тооцсон хүлээлтийн утга нь инфляцын утгыг шууд илэрхийлэхгүй болно.

мэдрэмжид суурилсан инфляцын хүлээлтийн утга болон чанарын хариултаас тооцсон хүлээлтийн утга ойролцоо байгаа нь цаашид үнийн өсөлт хэвээр хадгалагдах хандлагатайг илэрхийлж байна. Мөн тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга өмнөх улирлаас бага зэргийн өсөж **6.9%**-тай гарлаа /Зураг 1.2/.


Зураг 1.2: Инфляцын хүлээлт, ирэх 3 сард



Ирэх 12 сард буюу 2025 оны III улирлын инфляцын хүлээлтийн утга чанарын хариултын хувьд **5.5%**, мэдрэмжид суурилсан хариултаар **4.7%**, тоон хариултаас тооцсон утга **7.4%** байхаар хүлээгдэж байна. Чанарын хариултаас тооцсон хүлээлтийн утга нь мэдрэмжид суурилсан хүлээлтийн утгаас өндөр байгаа нь цаашид үнийн өсөлт аажмаар нэмэгдэж болзошгүй дохиог илтгэж байна. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга сүүлийн 2 улирал дараалан буурч 2021 оны III улирлаас хойших хамгийн бага түвшинд хүрээд байсан бол энэ удаад нэлээдгүй нэмэгдэж, 2022 оноос хойших дундаж утгатай ойролцоо түвшинд гарлаа /Зураг 1.3/.


<sup>2</sup> Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцсон болно.

Зураг 1.3: Инфляцын хүлээлт, ирэх 12 сард




ААН-үүдээс ирэх 3 сарын инфляцын талаарх хүлээлтийг тоон утгаар асуухад 13% нь үнэ 6.0 хүртэл хувиар, 71% нь 6.0-8.0 хүртэл хувиар, 11% нь 8.0-10.0 хүртэл хувиар, үлдсэн 5% нь 10.0-иас дээш хувиар өснө гэж хариулжээ. Харин ирэх 12 сарын инфляцын талаар судалгаанд оролцогчдын 9% нь үнэ 6.0 хүртэл хувиар, 66% нь 6.0-8.0 хүртэл хувиар, 17% нь 8.0-10.0 хүртэл хувиар, үлдсэн 9% нь 10.0-иас дээш хувиар өснө гэсэн хариултуудыг тус тус өгчээ. Тоон хариултын интервал тус бүрийн дундаж утгыг жигнэн, инфляцын хүлээлтийн утгыг тооцвол үнийн өсөлт ирэх 3 сард **6.9%**, ирэх 12 сард **7.4%**-тай байх хүлээлттэй байна /Зураг 1.4/.

Зураг 1.4: ААН-ийн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тархалт, тоон хариулт



Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийг борлуулалтын дийлэнх хувийг бүрдүүлдэг бараа, үйлчилгээний төрлийг үндэслэн ХҮИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, худалдаалдаг болон үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдээр нь тус тус бүлэглэлээ. Уг бүлгээр инфляцын талаарх хүлээлтийн хариултыг харьцуулахад ирэх 3 сард (2024.IV-богино хугацаа) холбоо, шуудан, гэр ахуйн бараа болон орон сууц, ус, цахилгааны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үнэ хамгийн ихээр өсөх хүлээлттэй байгаа бол талх, гурил, будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үнийн өсөлт харьцангуй тогтвортой байх буюу инфляц 6.0 хувиас бага байх хүлээлт давамгайлж байна /Зураг 1.5/.


Зураг 1.5: ААН-ийн ирэх 3 сарын инфляцын хүлээлт, тоон хариулт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/



Харин ирэх 12 сард (2025.III-урт хугацаа) дийлэнх аж ахуйн нэгжүүд үнийн өсөлт 8.0 хувиас бага байхаар хүлээж байгаа хэдий ч

холбоо, шуудан, тээврийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ болон бусад төрлийн хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд үнийн өсөлт 8.0 хувиас их байх хүлээлт давамгайлж байна /Зураг 1.6/.

**Зураг 1.6: ААН-ийн ирэх 12 сарын инфляцын хүлээлт, тоон хариулт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/**



Холбоо, шуудан, бусад төрлийн хүнс, тээврийн үйлчилгээ, хувцас, бөс, барааны үйлдвэрлэл, худалдаа болон боловсролын үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд богино болон урт хугацаанд 8.0-с дээш хувиар үнэ өсөх хүлээлт илүү давамгайлж байна. Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нь Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн 53.4 хувийн жинг тайлбарлах барааны бүлэг болдог. Өөрөөр хэлбэл, хэрэглээний сагсанд эзлэх хувь харьцангуй өндөр бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийн

төлөөллүүдэд инфляцын хүлээлт харьцангуй өндөр байна.

### III. Бизнесийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

#### Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI)<sup>3</sup>

Монгол Улсын эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас 5.9 нэгж хувиар буурч, 2024 оны III улиралд 100 хувийн утгатай гарлаа. Мэдрэмжийн үзүүлэлт сүүлийн 7 улирал дараалан 100-с дээш утгатай буюу эдийн засгийн нөхцөл байдал сайжрах мужид байсан бол энэ удаад өөрчлөлтгүй төлөвт шилжлээ. Ийнхүү эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас муудахад аж үйлдвэрийн салбарын өнгөрсөн улирлын шинэ захиалга буюу эрэлт буурсан нь голлох нөлөөг үзүүллээ /Зураг 2.1/.

**Зураг 2.1: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт**



Тэмдэглэл: Энэхүү үзүүлэлт нь эдийн засагт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, эдийн засгийн нөхцөл байдал), барааны нөөц, ирэх 3 сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар тодорхойлогдох бөгөөд Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалд тулгуурлан тооцлоо. Үзүүлэлт 100-с дээш гарах нь эдийн засгийн нөхцөл байдал

<sup>3</sup> Economic sentiment indicator (ESI)

сайжрах, 100-с бага бол эдийн засгийн нөхцөл байдал муудах төлөвийг илэрхийлнэ.

Тус үзүүлэлтийг ерөнхий салбаруудаар харвал үйлчилгээ болон хэрэглэгчдийн хувьд 100-с дээш утгатай (хэрэглэгч 108.2, үйлчилгээ 106.2) буюу эдийн засгийн нөхцөл байдал сайжирна гэсэн хүлээлттэй гарсан бол дотоод худалдаа болон аж үйлдвэрийн салбаруудад (дотоод худалдаа 96.3, аж үйлдвэр 92.6) агшилтын мужид шилжээд байна. Энэхүү үзүүлэлтийг өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад үйлчилгээний салбарт төдийлөн өөрчлөлт гараагүйг эс тооцвол бусад бүх салбарт үзүүлэлтүүд бага зэргийн буурсан (дотоод худалдаа -14.8, аж үйлдвэр -8.9, хэрэглэгч -7.9, барилга -1.8, үйлчилгээ +0.2) дүр зурагтай байна /Зураг 2.2/.

Зураг 2.2: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт, голлох салбаруудаар




Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын "European Business Cycle Indicators" тайлангийн аргачлалыг жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар жигнэн тооцсон болно.

### Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)<sup>4</sup>

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт 110 утгатай буюу 100-с дээш гарсан нь ажиллагсдын тоо ирэх улиралд нэмэгдэх хүлээлттэй байгааг илэрхийлж байна. Гэсэн

хэдий ч өмнөх улирын утгаас 4.3 нэгж хувиар буурсан нь цаашид энэхүү өсөлт саарах хандлагатайг харуулж байна /Зураг 2.3/. Энэхүү бууралтыг аж үйлдвэрийн салбарын хүлээлтийн утга буурсан нь голлон тайлбарлаж байна. Үндэсний статистикийн хорооны зарласан мэдээллээр Монгол Улсын ажиллагсдын тоо 2024 оны III улирлын байдлаар 1,360 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6%-иар буюу 34.1 мянгаар, өмнөх улирлаас 1.0%-иар буюу 13.2 мянгаар нэмэгджээ.


Зураг 2.3: Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлтийг голлох салбаруудаар харьцуулахад дотоод худалдаа болон үйлчилгээний салбаруудын хувьд ажиллах хүчнээ ирэх улиралд нэмэгдүүлэх (дотоод худалдаа 128.0, үйлчилгээ 112.0) хүлээлт давамгайлж байгаа бол аж үйлдвэр болон барилгын салбарт (аж үйлдвэр 97.8, барилга 93.4) ажиллагсдаа бууруулах төлөвтэй байна. Тус үзүүлэлтийг өмнөх улирлын утгатай харьцуулахад хүлээлт аж үйлдвэрийн салбарт хамгийн ихээр буурсан (аж үйлдвэр -21.4, барилга -8.3, үйлчилгээ +1.8, дотоод худалдаа +10.6) үзүүлэлттэй байна /Зураг 2.4/.

<sup>4</sup> Employment expectation indicator (EEI)

Зураг 2.4: Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар




Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг салбар тус бүрийн 2023 оны нийт ажиллагсдын тоонд эзлэх хувийн жингээр тооцсон болно.

### Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт (EUI)<sup>5</sup>

Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлын талаар аж ахуйн нэгж, иргэдээс асууж, хүлээлтийн утгыг тооцоход 2024 оны III улиралд өмнөх улирлаас 13 нэгж хувиар өсөж, 134 хувийн утгатай гарлаа. Тус үзүүлэлт нь 100-с дээш утгатай буюу эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэх мужид хэвээр байна /Зураг 2.5/. Мөн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт өмнөх улирлуудад буурч байсан хэдий ч энэ удаад бага зэргийн нэмэгдээд байна. Тухайлбал, ОУВС-аас эрхлэн гаргадаг “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд<sup>6</sup> дэлхийн улс орнуудад хүн амын тал орчмыг хамрах сонгуулийн үр дүнгээс шалтгаалж худалдаа, төсвийн бодлогод мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, улмаар урт хугацааны өсөлт болон нийлүүлэлтийн гинжин хэлхээний уян хатан байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх боломжтойг онцолсон байна.

Зураг 2.5: Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт



Эх сурвалж: Fred Economic data

Голлох салбаруудын хувьд авч үзвэл эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт хэрэглэгчдэд харьцангуй өндөр, харин дотоод худалдааны салбарт харьцангуй бага (хэрэглэгч 145.8, аж үйлдвэр 135.0, үйлчилгээ 128.3, барилга 127.9, дотоод худалдаа 113.2) гарлаа. Тус үзүүлэлтийг өмнөх улирлын утгатай харьцуулахад хэрэглэгчдийн хувьд болгоомжлол бага зэргийн буурсан бол аж үйлдвэр, барилга болон үйлчилгээний салбаруудад нэлээдгүй нэмэгдсэн (хэрэглэгч - 9.2, дотоод худалдаа +3.7, үйлчилгээ +14.7, барилга +17.2, аж үйлдвэр +23.7) төлөвтэй байна /Зураг 2.6/.

Зураг 2.6: Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт, голлох салбаруудаар



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт

<sup>5</sup> Economic uncertainty indicator (EUI)

<sup>6</sup> ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв 2024/10

нэмэгдэж байгааг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг салбарын хувьд тэнцүү жингээр тооцсон болно.

#### IV. Бизнесийн үйл ажиллагааны төлөв


##### Эрэлтийн талаарх хүлээлт

Ирэх 3 сарын борлуулалтын орлого одоогийн түвшнээс хэрхэн өөрчлөгдөх талаарх хүлээлтийг тандаж, эрэлтийн төлөвийг тодорхойлоход 2024 оны III улирлын хүлээлтийн утга 113 хувь буюу өмнөх улирлын утгаас 6.7 нэгж хувиар буурч, сүүлийн 7 улирал дараалан тэлэлтийн мужид хэвээр хадгалагдлаа /Зураг 3.1/. Энэ удаад аж үйлдвэр болон дотоод худалдааны салбаруудад тэлэлтийн мужаас агшилтын мужид шилжсэн бол үйлчилгээний салбар болон хэрэглэгчдийн хувьд тэлэлтийн мужид (хэрэглэгчдийн хэрэглээ 174.7, үйлчилгээ 109.1, дотоод худалдаа 95.1, аж үйлдвэр 92.9, барилга 91.8) хэвээр байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад барилга болон үйлчилгээний салбарт бага зэргийн өсөлттэй байгаа бол аж үйлдвэр болон дотоод худалдааны салбаруудад нэлээдгүй бууралттай (барилга +7.9, үйлчилгээ +1.5, хэрэглэгчдийн хэрэглээ -3.3, дотоод худалдаа -17.6, аж үйлдвэр -21.9) гарлаа /Зураг 3.2/.

Зураг 3.1: Эрэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 3.2: Эрэлтийн хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцоходоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно. Мөн хэрэглэгчдийн хувьд өрхийн хэрэглээ ирэх 3 сард энэ улирлаас хэрхэн өөрчлөгдөх талаарх хүлээлтийн асуулгыг оруулж тооцсон болно.

##### Экспортын талаарх хүлээлт

Экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдээс ирэх улирлын экспортын талаарх хүлээлтийг тодруулж, тайлант улирлын хүлээлтийн утгыг тооцоход 97 утгатай буюу өмнөх улирлаас 1.6 нэгж хувиар буурч, 2023 оноос хойш 5 улирал дараалан тэлэлтийн мужид гараад байсан хүлээлтийн утга сүүлийн 2 улиралд агшилтын мужид гараад байна /Зураг 3.3/. Монгол Улсын экспортын гүйцэтгэл 2024 оны эхний 10 сарын байдлаар 13,207 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6%-иар өсжээ. Уг өсөлт нь чулуун нүүрсний биет хэмжээний өсөлт (өмнөх оны мөн үеэс 13.8 сая тонноор өсөж, 65.9 сая тоннд хүрэв) болон зэсийн хүдэр, баяжмалын үнэ, тоо хэмжээний өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна<sup>7</sup>.


<sup>7</sup> Монголбанк, Гадаад худалдааны тойм 2024/10

Зураг 3.3: Экспортын хүлээлтийн үзүүлэлт



Экспортын хүлээлтийн үзүүлэлтийг голлох салбаруудын хувьд харвал зөвхөн дотоод худалдааны салбарт тэлэлтийн мужид хэвээр үлдсэн бол бусад салбаруудад агшилтын мужид (дотоод худалдаа 100.0, барилга 98.4, аж үйлдвэр 95.9, үйлчилгээ 93.4) шилжлээ. Тус үзүүлэлтийг өмнөх улиралтай харьцуулахад аж үйлдвэрийн салбараас бусад салбаруудад бага зэргийн бууралт (аж үйлдвэр +3.3, барилга -1.6, үйлчилгээ -3.3, дотоод худалдаа -4.8) ажиглагдлаа. /Зураг 3.4/.

Зураг 3.4: Экспортын хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь үзүүлэлт нэмэгдсэн утгыг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцоходоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно.

<sup>8</sup> ҮСХ-ны ӨНЭЗС-ны 2021 үр дүнгээс харахад өрхийн сарын дундаж нийт орлогын 43 хувийг цалингийн орлого бүрдүүлдэг байна.

## Ажиллах хүчний зардлын талаарх хүлээлт

Нэгж ажиллах хүчний зардлын талаарх хүлээлтийн утга өмнөх улирлын утгаас 7.7 нэгж хувиар өсөж, тайлант улиралд 158 утгатай гарснаар, цаашид ажиллах хүчний зардлаа (ажилчдын цалин) нэмэгдүүлэх хандлага нийт аж ахуйн нэгжүүдэд давамгайллаа /Зураг 3.5/.

Зураг 3.5: Ажиллах хүчний зардлын хүлээлтийн үзүүлэлт



Ажиллах хүчний зардлын үзүүлэлтийг голлох салбаруудын хувьд авч үзвэл барилга, дотоод худалдаа болон аж үйлдвэрийн салбаруудад нэлээдгүй өсөлттэй (барилга +18.3, дотоод худалдаа +16.4, аж үйлдвэр +12.5) гарсан бол бусад салбаруудад (өрхийн орлого -6.1, үйлчилгээ -2.5) буурсан төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, ажил олгогчдын зүгээс ажиллах хүчний зардлаа үргэлжлүүлэн нэмэгдүүлэх хүлээлт давамгайлж, цаашид ч энэхүү өсөлт нэмэгдэх хандлагатай байна. Харин хэрэглэгчдийн зүгээс цалингийн орлого<sup>8</sup> буурах хүлээлт давамгайлж байна /Зураг 3.6/.

**Зураг 3.6: Ажиллах хүчний зардлын хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар**



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцохдоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно. Мөн хэрэглэгчдийн хувьд өрхийн орлого ирэх 3 сард энэ улирлаас хэрхэн өөрчлөгдөх талаарх хүлээлтийн асуулгыг оруулж тооцсон болно.


### Хөрөнгө оруулалтын талаарх хүлээлт

Аж ахуйн нэгжүүдээс ирэх улиралд газар, барилга, тоног төхөөрөмж болон техник хэрэгслээ шинээр авах эсвэл өргөжүүлэх чиглэлд хөрөнгө оруулалтын зардлаа нэмэгдүүлэх талаар асууж, хөрөнгө оруулалтын хүлээлтийн үзүүлэлтийг тооцоход 130 утгатай гарч, одоогийн түвшнээс хөрөнгө оруулалтын зардлаа нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа тэлэх хүлээлттэй байна /Зураг 3.7/. Голлох салбаруудын хувьд авч үзэхэд зөвхөн барилгын салбарт өмнөх улирлаас нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд зарим салбаруудад нэлээдгүй буурсан (барилга +4.7, дотоод худалдаа -1.1, үйлчилгээ -12.7, аж үйлдвэр -24.4) төлөвтэй байна /Зураг 3.8/.

**Зураг 3.7: Хөрөнгө оруулалтын хүлээлтийн үзүүлэлт**



**Зураг 3.8: Хөрөнгө оруулалтын хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар**



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь үзүүлэлт нэмэгдсэн утгыг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцохдоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно.

### Нэгж бүтээгдэхүүний зардлын талаарх хүлээлт

Нэгж бүтээгдэхүүний дундаж зардал ирэх улиралд хэрхэн өөрчлөгдөх талаар аж ахуйн нэгжүүдээс тодруулж, хүлээлтийн үзүүлэлтийг тооцоход 167 утгатай буюу өмнөх улирлын үзүүлэлтээс 14.4 нэгж хувиар нэмэгдлээ /Зураг 3.9/. Нэгж бүтээгдэхүүний зардлын үзүүлэлтийн хувьд бүх салбарт 100-с дээш утгатай буюу бүх салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг нэмэгдэх төлөв хэвээр байх бөгөөд өмнөх улирлын утгатай харьцуулахад бүх салбарт нэлээдгүй

нэмэгдээд (барилга +20.6, аж үйлдвэр +17.7, үйлчилгээ +10.2, дотоод худалдаа +9.2) байна /Зураг 3.10/. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчдийн хувьд нэгж бүтээгдэхүүний өртөг цаашид нэлээдгүй нэмэгдэнэ гэж үзэж байна.

**Зураг 3.9: Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт**



**Зураг 3.10: Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар**



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь төгрөг сулрах утгыг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцохдоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно.

### Гадаад валютын ханшийн талаарх хүлээлт


Гадаад валютын ханшийн ирэх 3 сарын хүлээлтийн утга тайлант улиралд 131 утгатай буюу өмнөх улирлаас 2.1 нэгж хувиар буурч, сүүлийн 5 улирал дараалан төгрөг сулрах

мужид гарлаа /Зураг 3.11/. Ханшийн хүлээлтийн үзүүлэлт бүх салбаруудад төгрөг сулрах мужид гарсан хэдий ч өмнөх улирлын үзүүлэлттэй харьцуулахад үйлчилгээ болон барилгын салбаруудад хүлээлтийн утга ихээхэн буурсан (үйлчилгээ -23.4, барилга -16.7) бол хэрэглэгчдийн хувьд нэлээдгүй нэмэгдсэн (хэрэглэгч +29.0) төлөвтэй буюу төгрөг нэлээдгүй сулрах хүлээлттэй байна /Зураг 3.12/.

**Зураг 3.11: Гадаад валютын ханшийн хүлээлтийн үзүүлэлт**



**Зураг 3.12: Гадаад валютын ханшийн хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар**



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь төгрөг сулрах утгыг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцохдоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно.


## Зээлийн хүүний талаарх хүлээлт

Зээлийн хүүний ирэх 3 сарын хүлээлтийн үзүүлэлтийг харахад зээлийн хүү өсөх хүлээлттэй буюу өмнөх улирлын хүлээлтийн утгаас бага зэргийн өсөж, 131 утгатай гарлаа /Зураг 3.13/. Голлох салбаруудын хувьд өмнөх улирлын хүлээлтийн утгыг харьцуулахад нэлээдгүй нэмэгдэж (барилга +24.3, аж үйлдвэр +15.3, дотоод худалдаа +8.6, үйлчилгээ +7.7, хэрэглэгч +1.4) бүх салбаруудад зээлийн хүү цаашид нэмэгдэх хүлээлт давамгайлж байна /Зураг 3.14/.

Зураг 3.13: Зээлийн хүүний хүлээлтийн үзүүлэлт



Зураг 3.14: Зээлийн хүүний хүлээлтийн үзүүлэлт, голлох салбаруудаар



Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт

<sup>9</sup> ААН-үүдээс ирэх хугацааны үнийн өсөлт ямар байх талаар асууж, өснө, буурна гэсэн хариултуудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцлоо.

өсөж байгааг илтгэх бөгөөд тус үзүүлэлтийг тооцохдоо салбар бүрийн жинг тэнцүү байдлаар авч үзсэн болно.

## Үнийн мэдрэмжийн үзүүлэлт

Өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны үнийн өөрчлөлтийг аж ахуйн нэгжүүд хэрхэн мэдрч байгаа талаарх мэдрэмжийн индексийг<sup>9</sup> тооцоход 2021 оны I улирлаас хойш тасралтгүй нэмэгдэж ирсэн тус үзүүлэлт 2024 он гараад буураад байсан бол энэ удаад өнгөрсөн 3 сарын мэдрэмжийн үзүүлэлт бага зэргийн нэмэгдэж, “үнийн өсөлт одоогийн түвшинд” хадгалагдах мужид хэвээр гарлаа /Зураг 3.15/.

Зураг 3.15: Үнийн мэдрэмжийн үзүүлэлт



## V. Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ерөнхий мэдээлэл

- Түүвэр судалгааг 2024 оны 11 дүгээр сард явуулж, нийт 378 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан бөгөөд өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 365 (97%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 8 (2%) нь хувьцаат компани (ХК), үлдсэн 5 нь бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй ААН-үүд байна /Хүснэгт 1.1/.
- Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны 82 (22%), хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн 62 (16%), барилгын 61 (16%), хүнсний бус боловсруулах үйлдвэрлэлийн 45 (12%) ААН-үүд судалгаанд түлхүү хамрагдлаа /Хүснэгт 1.2/.
- Хувийн хэвшлийн ААН-үүд судалгаанд голлон хамрагдсан бөгөөд тэдгээрийн 33% нь 20-с дээш, 25% нь 10-15 жилийн, 21% нь 5-10 жилийн туршид үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай ААН-үүд байна /Хүснэгт 1.3/.
- Жилийн борлуулалтын орлогоор авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 149 (39%), 300 саяас 1.0 тэрбум төгрөгийн орлоготой 79 (21%), 50.0-300.0 сая төгрөгийн орлоготой 72 (19%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1.4/.

**Хүснэгт 1.1: Аж ахуйн нэгжийн тоо /өмчлөлөөр/**

| Өмчлөлийн хэлбэрийн ангилал | тоо        | хувь        |
|-----------------------------|------------|-------------|
| ХХК                         | 365        | 97%         |
| Хувьцаат компани            | 8          | 2%          |
| Бусад                       | 5          | 1%          |
| <b>НИЙТ ДҮН</b>             | <b>378</b> | <b>100%</b> |

**Хүснэгт 1.2: Аж ахуйн нэгжийн тоо /салбараар/**

| Салбарын ангилал                      | тоо        | хувь        |
|---------------------------------------|------------|-------------|
| Уул уурхай, олборлолт                 | 10         | 3%          |
| Боловсруулах үйлдвэрлэл (хүнсний)     | 62         | 16%         |
| Боловсруулах үйлдвэрлэл (хүнсний бус) | 45         | 12%         |
| Барилга                               | 61         | 16%         |
| Бөөний болон жижиглэнгийн худалдаа    | 82         | 22%         |
| Тээвэр, агуулахын үйл ажиллагаа       | 13         | 3%          |
| Зочид буудал, байр, сууц болон хоол   | 9          | 2%          |
| Мэдээлэл, холбоо                      | 8          | 2%          |
| Санхүүгийн болон даатгалын ү.а        | 14         | 4%          |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх ү.а  | 17         | 4%          |
| Боловсрол                             | 9          | 2%          |
| Хүний эрүүл мэнд, нийгмийн халамж     | 7          | 2%          |
| Бусад                                 | 41         | 11%         |
| <b>НИЙТ ДҮН</b>                       | <b>378</b> | <b>100%</b> |

**Хүснэгт 1.3: Аж ахуйн нэгжийн тоо /туршилага, жилээр/**

| Хугацааны ангилал | тоо        | хувь        |
|-------------------|------------|-------------|
| 5 хүртэл          | 26         | 7%          |
| 5-10 хүртэл       | 80         | 21%         |
| 10-15 хүртэл      | 95         | 25%         |
| 15-20 хүртэл      | 51         | 13%         |
| 20-с дээш         | 126        | 33%         |
| <b>НИЙТ ДҮН</b>   | <b>378</b> | <b>100%</b> |

**Хүснэгт 1.4: Аж ахуйн нэгжийн тоо /орлогоор/**

| Орлогын ангилал                  | тоо        | хувь        |
|----------------------------------|------------|-------------|
| 50 сая төгрөг хүртэл             | 32         | 8%          |
| 50-300 сая төгрөг хүртэл         | 72         | 19%         |
| 300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл | 79         | 21%         |
| 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл     | 46         | 12%         |
| 2.5 тэрбум төгрөгөөс дээш        | 149        | 39%         |
| <b>НИЙТ ДҮН</b>                  | <b>378</b> | <b>100%</b> |

- Жилийн борлуулалтын орлого болон ажилчдын тооны бүлгээр ангилбал 10 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой бичил ангилалд хамаарах 148 (39%), 10-аас 200 хүртэл ажилтантай жижиг, дунд ангилалд хамаарах 80 (21%), 200-с дээш ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой том ангилалд хамаарах 150 (40%) аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.5/.

Хүснэгт 1.5 | Аж ахуйн нэгжийн тоо /орлого, ажилтны тооны бүлгээр/

| Борлуулалтын орлого              | Ажилчдын тоо /бүлгээр/ |            |           |           | Бүгд        |
|----------------------------------|------------------------|------------|-----------|-----------|-------------|
|                                  | < 10                   | 11–49      | 50–199    | 200= <    |             |
| 50 сая төгрөг хүртэл             | 29                     | 3          | 0         | 0         | 8%          |
| 50-300 сая төгрөг хүртэл         | 61                     | 9          | 1         | 1         | 19%         |
| 300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл | 43                     | 34         | 2         | 0         | 21%         |
| 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл     | 15                     | 26         | 5         | 0         | 12%         |
| 2.5 тэрбум төгрөгөөс дээш        | 9                      | 58         | 62        | 20        | 39%         |
| <b>НИЙТ ДҮН</b>                  | <b>157</b>             | <b>130</b> | <b>70</b> | <b>21</b> | <b>100%</b> |

## VI. Хавсралт 2. Аргачлалын тайлбар

### Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн болон хэрэглэгчдийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын аж ахуйн нэгж, хэрэглэгчдээс сонгогдсон асуултуудад өгсөн хариултуудын жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Аж үйлдвэр (жин 40%), үйлчилгээ (30%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), барилгын салбарууд (5%) хамаарна. Аж үйлдвэрийн салбараас тухайн улирлын *шинэ захиалга*, *бэлэн бүтээгдэхүүний нөөц*, ирэх улирлын *үйлдвэрлэл*, барилгын салбараас тухайн улирлын *шинэ захиалга*, ирэх улирлын *ажил эрхлэлт*, дотоод худалдааны салбараас тухайн улирлын *борлуулалтын орлого*, *худалдан борлуулах барааны нөөц*, ирэх улирлын *борлуулалтын орлого*, үйлчилгээний салбараас тухайн улирлын *бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал*, *шинэ захиалга*, ирэх улирлын *борлуулалтын орлого*, хэрэглэгчдээс тухайн улирлын *санхүүгийн байдал*, ирэх улирлын *санхүүгийн байдал*, *хэрэглээ* болон *эдийн засгийн нөхцөл байдал* зэрэг үзүүлэлтүүдийг асууж, асуулт тус бүрийн эерэг сөрөг хариултуудын нийт хариултад эзлэх хувийн зөрүүгээр тодорхойлсон болно.